



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.АНГАРТ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЛБАН ШААРДЛАГА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,

Утас/факс: 32-90-84

2015.02.16 № 18
танай _____-ны № _____-т

Үүрэг, даалгавар өгөх тухай

1. Үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог Т+3 горимд гүйцэтгэх тухай

Хорооноос 2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр “Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны горимд зарим өөрчлөлт оруулах тухай” 67 дугаар тогтоолыг баталсан билээ.

Гэтэл энэхүү тогтоолын 3 дахь заалт биелэгдээгүй буюу “ҮЦТТТХТ” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдаагүйгээс Т+1 журмын болон гурвалсан гэрээний төслүүд батлагдаагүй байна. Үүнээс үүдэн брокерын компаниуд болон төлбөр гүйцэтгэх банкуудын гэрээний баталгаажуулалт хийгдээгүй болно.

2. Үүрэг, даалгавар өгөх тухай

“ҮЦТТТХТ” ХХК, төлбөр гүйцэтгэх банкны дотоод журам, гэрээний зохицуулалтууд бүрэн хийгдэж дуусах хүртэл үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоог 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Т+3 горимоор хэрэгжүүлэх үүргийг өгч байна.

3. Үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ:

Өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25.1.7-д заасан захиргааны хариуцлага ногдуулахыг анхааруулж байна.

УЛСЫН БАЙЦААГЧ



А.АВИР